



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 9/14

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 а, 29.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалт, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.1.16, 1.1.13.1, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүсийн оношлогоо эмчилгээний төв нь иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэн, хүлээгдэл чирэгдлийг бууруулж, тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор “Үйлчилгээний соёл-Иргэдийн сэтгэл ханамж” аяныг шинэлэг байдлаар зохион байгуулахад дэмжлэг үзүүлж шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 9 998 000 /Есөн сая есөн зуун ерэн найман мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ